

# МОНГОЛ УЛСЫН ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДИТ ӨСӨЛТИЙН СУДАЛГАА: 2008-2018

*Л. Амартүвшин*

*Доктор (Ph. D.), дэд профессор  
Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Бизнесийн удирдлага,  
хүмүүнлэгийн сургууль*

*amartubshin@hotmail.com*

*Л. Чулуунцэцэг*

*Шинжлэх ухаан, технологийн их сургууль. Механик, тээврийн  
сургууль*

*chuluunts25@yahoo.com*

**Хураангуй:** Монгол улсад цалин хөлсний дундаж хэмжээ сүүлийн 10 жилд хурдацтай өссөн статистик дүнг харуулж байгаа билээ. Иргэдийн хөдөлмөрийн үнэлэмж өсч дундаж цалингийн нэрлэсэн хэмжээ өсч байгаа нь сайшаалтай боловч бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өсөлт буюу инфляцийн түвшний нөлөөллийг тооцож цалин хөлсний бодит өсөлтийг тодорхойлох нь хүмүүсийн амьжиргааны түвшний өсөлтийг бодитоор гаргах, эдийн засгийн бодлого боловсруулахад чухал ач холбогдолтой байдаг. Энэхүү судалгааны өгүүллэгийн үндсэн зорилго нь Монгол Улсад 2008-2018 онуудад дундаж цалингийн бодит өсөлтийн хэмжээг тодорхойлсны үндсэн дээр иргэдийн амьжиргааны түвшин тухайн хугацаанд хэрхэн сайжирсныг эдийн засгийн талаас нь тооцоолж гаргах явдал юм. 2008-2018 онуудын эдийн засаг, нийгмийн статистик мэдээллийг үндэслэн статистик шинжилгээний аргуудыг ашиглан уг судалгааг гүйцэтгэв.

**Түлхүүр үг:** Цалин хөлс, дундаж цалин хөлс, амьжиргааны түвшин, инфляци

## УДИРТГАЛ

Монгол улсын эдийн засаг 2018 оны урьдчилсан гүйцэтгэлээр 6,9 хувьд хүрч сүүлийн 4 жилийн хугацаанд хамгийн өндөр хувиар өссөн байна. Эдийн засаг ийнхүү өсөхөд экспортын орлого 14 хувиар, гадаадын шууд хөрөнгө оруулалт 32 хувиар өссөн, төсвийн сахилга бат сайжирч төсвийн алдагдал буурсан, банкны салбарт хувийн хэвшилд олгох зээлийн хэмжээ нэмэгдсэн зэрэг хүчин зүйлүүд голлох нөлөөг үзүүлсэн байна (Сангийн яам, 2019). Эдийн засгийн өсөлттэй уялдаа холбоотойгоор дундаж цалингийн хэмжээ сүүлийн жилүүдэд тогтвортой өсч ирсэн дүнг харуулж ирсэн байдаг. Үндэсний статистикийн хорооны 2018 оны тайлан мэдээнд нийгмийн даатгалын шимтгэл төлөгч 38,5 мянган аж ахуйн нэгжид ажилладаг 613,9 мянган иргэний цалинг үндэслэж ажиллагсдын дундаж цалин 1120.3 мянган төгрөг болсон бөгөөд дундаж цалингийн

хэмжээ 2017 онтой харьцуулахад 175.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн статистик дүн гарсан байна. Нийт ажиллагчдын 13.2 хувь нь 300 мян.төг хүртэлх, 49.2 хувь нь 300.0-900.0 мян.төг хүртэлх, 24.4 хувь нь 900.0-1500.0 хүртэлх, 13.2 хувь нь 1500.0 мян.төгрөгөөс дээш цалинтай байна (Үндэсний статистикийн хороо, 2019). Салбараар нь цалингийн дундаж хэмжээг авч үзвэл уул уурхай, олборлолтын салбар 2119.1 мян.төг, олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн газрууд 1710.0 мян.төг, мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа 1569,7 мян.төг, барилга 852,3 мян.төг, төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал, 832,2, бөөний болон жижиглэн худалдаа 793,3 мян.төг, боловсруулах үйлдвэрлэл 1088.2 мян.төг, мэдээлэл холбоо 865,8 мян.төг, ХАА 681,5 мян.төг, боловсрол 720,8 мян.төг, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 585.0 мян.төгрөгний дундаж цалинтай гэж тус тус гарсан байна. Эндээс үзэхэд уул уурхайн салбарт ажиллаж байгаа хүмүүсийн дундаж цалин хамгийн өндөр, зочид буудал, нийтийн хоолны салбарт ажиллагсдын дундаж цалин хамгийн бага гэсэн үр дүнг харуулж байна.

Монгол Улсад дундаж цалингийн хэмжээ сүүлийн жилүүдэд тасралтгүй өсч байгаа гэсэн үр дүнг харуулж байгаа боловч иргэдийн хувьд энэхүү өсөлт нь эдийн засгийн бодит утгатай эсэхт эргэлзэж тээнэгэлзэх асуудал байнга гарах болсон. Түүнчлэн дундаж цалингийн өсөлт нь иргэдийн бодит орлогыг ямар хэмжээгээр өсгөж байгааг судалж тооцоолох шаардлага өндөр байна. Иймд судалгааны өгүүлэгийн хүрээнд Монгол Улсад 2008-2018 онуудад дундаж цалингийн бодит өсөлтийн хэмжээг эдийн засгийн хувьд тодорхойлон гаргах зорилго дэвшүүлээ. Судалгаанд 2008-2018 онуудын эдийн засаг, нийгмийн статистик мэдээлэлд тулгуурлан статистик шинжилгээний аргуудыг ашиглан шинжилгээ хийв.

## **ОНОЛ, АРГА ЗҮЙ**


Эдийн засгийн хувьд ажиллагсдын нэрлэсэн орлого ба бодит орлогын хоорондын ялгааг ойлгох нь туйлын чухал байдаг. Мөнгөн буюу нэрлэсэн орлого нь хүмүүсийн цалин хөлс, рент, хүү, ашгийн хэлбэрээр авдаг нийт мөнгөний хэмжээ байдаг бол бодит орлого нь нэрлэсэн орлогоороо худалдан авч чадах бараа, үйлчилгээний тоо хэмжээгээр тодорхойлогддог (McConnell & Brue, 2006). Иргэдийн орлогыг тодорхойлогч эдийн засгийн гол үзүүлэлт нь цалин хөлс юм. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Цалин хөлсийг хамгаалах тухай 1949 оны 95-р конвенцид “Цалин хөлс гэж ажилтныг ажилд авсан тухай амаар болон бичгээр байгуулсан гэрээний дагуу түүний хийж гүйцэтгэсэн, эсхүл хийж гүйцэтгэвэл зохих

ажил үйлчилгээнийх нь төлөө ажил олгогчоос үндэсний хууль тогтоомж болон гэрээ хэлэлцээрийн үндсэн дээр тогтоон олгож буй аливаа мөнгөн урамшуулал буюу ажлын хөлсыг хэлнэ” гэж тодорхойлсон байна. Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 4-р бүлгийн 47.1-р зүйлд “Цалин хөлс нь үндсэн цалин, нэмэгдэл, нэмэгдэл хөлс, олговор, шагнал, урамшууллаас бүрдэнэ” гэж тодорхойлсон байна. Монгол Улсын Нийгмийн хамгаалал, Хөдөлмөрийн яамны сайдын 2005 оны 55-р тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-д “Ажилтны дундаж цалин хөлсийг тодорхойлох үндсэн баримт нь ажилтны цалин хөлсны цэс, данс бүртгэл байна” гэж тодорхойлсон байна. Монгол Улсад Үндэсний статистикийн хороо нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын иргэдийн цалин хөлсний нийгмийн даатгал төлөгдсөн цалин хөлсний мэдээлэлд тулгуурлан иргэдийн дундаж цалин хөлсний хэмжээг тооцож гаргаж байна. Дундаж цалингийн өсөлт нь хэдийгээр хүмүүсийн орлогын түвшингийн өсөлтийг тодорхой хэмжээгээр харуулах боловч инфляци нь дундаж цалингийн өсөлтөөс өндөр үед эсрэгээр хүмүүсийн амьжиргааны түвшинг буурч болохыг эдийн засгийн хувьд харуулах боломжтой байдаг(Бакей, Оросоо, 2002). Орлогын бодит өсөлт нь нэрлэсэн өсөлтөнд инфляцийн түвшний нөлөөг тооцоолох явдал юм. Эдийн засгийн хувьд бодит орлогын өөрчлөлт буюу өсөлтийг дараах томъёогоор тодорхойлдог (Hall & Lieberman, 2010) . Бодит орлогын өөрчлөлт=Нэрлэсэн орлогын өөрчлөлт (%)-инфляцийн түвшин(%) (1). Энд тодорхойлсноор нэрлэсэн орлого үнийн түвшний өсөлт буюу инфляцийн түвшнөөс хурдан өсч байгаа бол бодит орлого өсч байна гэсэн үг. Хэрвээ үүний эсрэг инфляци нь нэрлэсэн орлогийн өсөлтөөс илүү хурдаар өсч байгаа бол бодит орлого багасч байгааг илэрхийлдэг. Энэхүү томъёог ашиглан бодит цалин хөлсний өсөлтийн хурдыг тодорхойлов. Судалгаанд динамик эгнээий цэвэр өсөлтийн хурдыг тооцох аргыг ашиглав.

## **ДУНДАЖ ЦАЛИН ХӨЛСНИЙ БОДИТ ӨСӨЛТИЙН ШИНЖИЛГЭЭ**

Монгол Улсад дундаж цалингийн хэмжээ 2008-2018 онуудад жил бүр өссөн үр дүнг үзүүлснийг Зураг 1-т харуулж байна. Тухайлбал 2008 онд 274.2 мян.төгрөг байснаас жил бүр өсч 2017 онд 944.5 мян.төгрөгт хүрч нэмэгдсэн байна.


Зураг 1. Дундаж цалингийн хэмжээ 2008-2017 онуудад



*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2018*

Нийт бараа, үйлчилгээний үнийн ерөнхий түвшний өсөлтийг илэрхийлэх инфляцийн түвшин манай улсад 2008-2018 онуудад мөн өсч байгааг зураг 2-оос харж болно. Өнгөрсөн хугацаанд инфляцийн түвшин жил бүр харилцан адилгүй байсан бөгөөд сүүлийн жилүүдэд буюу 2015 оноос хойш харьцангуй буурч нэг оронтой тоонд шилжсэн байна.

Зураг 2. Инфляцийн түвшин 2008-2018 онуудад



*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, 2018*

Хүснэгт 1-д 2008-2018 онуудад дундаж цалингийн өсөлт ба дундаж цалингийн бодит өсөлтийн хувийг 2008 оноор суурь болгон авч жил бүрийн өсөлтийг инфляцийн түвшинтэй уялдуулан тооцож тодорхойлов. 2008 онд ажиллагсдын дундаж цалингийн хэмжээ 274.2 мян.төгрөг байсан бол жил бүр өсч улмаар 2018 онд 1120.3 мян.төгрөгт хүрсэн байна. 2008-2018 онуудад цалингийн хэмжээний харьцангуй өсөлтийн хувийг ажиглавал 2012 онд хамгийн өндөр буюу 31.4 хувиар, 2015 онд хамгийн бага буюу 1.4 хувиар өссөн дүнг харуулж байна. Нэрлэсэн цалингийн өсөлт 2015 онд өссөн дүнг илэрхийлсэн боловч бодит цалингийн өсөлт 2015 онд -0.47 хувиар буурсан байна. Бодит цалингийн өсөлтийн хувийг дээрх онуудад ажиглавал 2012 онд хамгийн өндөр буюу 17.45 хувиар өссөн үр дүнг илэрхийлж байна

Хүснэгт 1. Дундаж цалингийн нэрлэсэн ба бодит өсөлт, инфляцийн түвшин 2008-2018 онуудад

Он	Дундаж цалин (мян.төг)	Жилийн дундаж цалингийн харьцангуй өсөлт, хувиар	Инфляцийн түвшин, хувиар	Дундаж цалингийн бодит өсөлт, хувиар
2008	274,2			
2009	300,4	9,6	4,2	5,36
2010	341,5	13,7	13,0	0,68
2011	424,2	24,2	8,9	15,32
2012	557,6	31,4	14,0	17,45
2013	720,4	29,2	12,5	16,69
2014	796,6	10,6	10,4	0,19
2015	808,0	1,4	1,9	-0,47
2016	861,9	6,7	1,3	5,37
2017	944,5	9,6	6,4	3,18
2018	1120,3	18,6	8,1	10,51
2008-2018		308,6	215,6	93,0

Тайлбар: 2009-2018 инфляцийн түвшний нийт өссөн дүнг геометр прогрессийн аргаар тодорхойлов.

2008-2018 онуудын жилийн дундаж нэрлэсэн цалингийн харьцангуй өсөлтийн хувийг нийт дүнгээр нь авч үзвэл цалин 308,6 хувиар өссөн байхад тухайн хугацаанд үнийн түвшин 215,6 хувь буюу өргөн хэрэглээний бүтээгдэхүүний дундаж үнэ ойролцоогоор 2 дахин өссөн байна. 2008 оныг 2018 онтой харьцуулж авч үзэхэд ажиллагсдын дундаж цалингийн бодит өсөлтийн хэмжээ 93,0 хувиар өссөн байна. Эндээс үзэхэд ажиллагсдын дундаж цалингийн өсөлт нь эдийн засгийн хувьд бодитой иргэдийн амьжиргааны түвшин харьцангуй 2 дахин нэмэгдсэн байна гэж дүгнэж болохоор байна. Өөрөөр хэлбэл 2008-2018 оны хооронд дундаж иргэдийн амьжиргааны түвшин эрс дээшилж бараа, үйлчилгээг худалдан авах чадавх нь бодитой нэмэгдсэн байна гэж дүгнэж болно.

## ДҮГНЭЛТ

Цалин хөлсний дундаж хэмжээ, түүний өсөлт нь тухайн улсын эдийн засгийн өсөлт, орлогын тэгш хуваарилалт, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох эдийн засгийн чухал хэмжигдэхүүн нь болж байдаг. Судалгаанд Монгол Улсын 2008-2018 онуудын цалин хөлсний дундаж хэмжээ ба түүний бодит өсөлтийн хэмжээг инфляцийн түвшинг харгалзан тодорхойлж үзэв. 2008-2018 онуудад нэрлэсэн цалингийн хэмжээ жил бүр өсч байсан үр дүнг илэрхийлж байсан бөгөөд бодит цалингийн өсөлтийг инфляцийн түвшинтэй уялдуулан тооцож үзэхэд 2015 оноос бусад онуудад бодит цалин тууштай нэмэгдэж байсан байна. 2008 ба 2018 онуудыг харьцуулан авч үзвэл нэрлэсэн цалин нийт 308,6 хувиар өссөн буюу ойролцоогоор 4 дахин нэмэгдсэн үр дүнг харуулж байгаа боловч дундаж

цалингийн бодит өсөлт нь 93.0 хувиар өссөн буюу бараг 2 дахин өссөн дүнг харуулж байна. Энэхүү үр дүнгээс үзэхэд иргэдийн дундаж цалингийн хэмжээ эдийн засгийн талаас бодитой бөгөөд амьжиргааны түвшин эрс дээшлэхэд нөлөөлсөн гэж дүгнэж болно. Хэдийгээр ажиллагсдын дундаж цалингийн хэмжээ өсч байгаа үр дүнг харуулж байгаа боловч энэ нь салбар бүрт харилцан адилгүй байгаа бөгөөд манай улсын хувьд уул уурхайн салбарт ажиллагсдын цалин хамгийн өндөр, зочид буудал, нийтийн хоолны салбарт ажиллагсдын цалин хамгийн бага байна. 2018 оны Үндэсний статистикийн хорооноос гаргасан судалгааны үр дүн нь ажиллагсдын цалин хөлсний хэмжээ нь салбар бүрт харилцан адилгүй, салбар хоорондын дундаж цалингийн ялгаа өндөр байгааг харуулж байна. Иргэдийн 49.2 хувь буюу бараг тал нь 300.0-900.0 мян.төгрөгний цалинтай байгаа бөгөөд улсын дүнгээр цалингийн дундаж хэмжээний өсөлт нь нийт иргэдийн цалин хөлсний бодит өсөлтийн дундаж хэмжээг илэрхийлэн гаргахад учир дутагдалтай үзүүлэлт юм. Түүнчлэн инфляцийн түвшний өсөлт нь бүх бараа, үйлчилгээний үнийн өсөлт биш бөгөөд хэрэглэгчдийн гол хэрэглэдэг багц бүтээгдэхүүний үнийн дундаж өсөлтөөр тодорхойлогддог тул зарим тохиолдолд үнийн өсөлтийг бүрэн илэрхийлэх боломжгүй байдаг.

## **НОМ ЗҮЙ**

- [1] Монгол Улсын Сангийн яам: <https://www.mof.gov.mn/>
- [2] Үндэсний Статистикийн хороо, Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалингийн судалгаа, 2017
- [3] McConnell & Brue, Economics, IrwinProfessionalPub, 2006
- [4] Хөдөлмөрийн судалгааны институт, Цалин хөлсний бүтцийн судалгаа, 2013
- [5] УИХ, Хөдөлмөрийн тухай хууль, 1999
- [6] Бакей, А., Оросоо, Р., Эдийн засгийн ухаан, УБ, 2002
- [7] Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Дундаж цалин хөлс тодорхойлох журам, 2005
- [8] Hall, E. & Lieberman. M., Economics: Principles & Applications, USA, Cengage Learning
- [9] Үндэсний статистикийн хороо, Монгол Улсын Статистикийн эмхтгэл:2008-2017